**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2026 оны 01 дүгээр сарын 21 Дугаар БА-020/2026 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 2 давхар зоорьтой 2 давхар 5 блок, 1 давхар зоорьтой 3 давхар 2 блок, нийт 7 блок аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамж шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/11/19 огноо, дугаар: БА32024/0859,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ХАТ-34/13

2.3. Захиалагч: Одод ХХК оноосон нэр, 9011072133 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2066505 регистрийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Тээвэрчдийн гудамж, өөрийн байр, холбоо барих утас: 11-324524, 91113484, цахим шуудангийн хаяг: bilegtu@gmail.com,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Эл Жи Жи И ХХК оноосон нэр, 9011291087 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5488664 регистрийн дугаар, БУ18-149/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар:, хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Нийслэл хүрээ өргөн чөлөө, 365 дугаар байр 500 тоот, холбоо барих утас: 91910028, 91910258, цахим шуудангийн хаяг: tuvshinbayar.e@lgge.mn,

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Оч арвин инженеринг ХХК оноосон нэр, 9011816501 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6548679 регистрийн дугаар, БУ18-779/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, 4 дүгээр хэсэг, Их дарь эх 10, 312 тоот, холбоо барих утас: 99101688, цахим шуудангийн хаяг: och.arvin.engineering@gmail.com,

Адрестос ХХК оноосон нэр, 9011328039 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5547814 регистрийн дугаар, БУ16-220/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Сүхбаатарын гудамж 13-401 тоот, холбоо барих утас: 99056754, цахим шуудангийн хаяг: rasuulmsl@gmail.com,

Эйрдактинг системс ХХК оноосон нэр, 9011457122 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5795176 регистрийн дугаар, БУ17-820/18 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 25 дугаар хороо, Хайрхан 2, 107 тоот, холбоо барих утас: 94488584, цахим шуудангийн хаяг: och.arv@gmail.com,

Ви Ти Икс ХХК оноосон нэр, 9011061019 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5087058 регистрийн дугаар, БУ18-09/18 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, Москвагийн гудамж, 18 тоот, холбоо барих утас: 88000660, 88009341, цахим шуудангийн хаяг: vtx@gmail.com,

2.6. Барилгын зураг төсөл зохиогч байгууллага: Хатанбаатар ХХК оноосон нэр, 9011039098 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2090473 регистрийн дугаар, ЗТ11-473/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, 45/4 байр 601 тоот, холбоо барих утас: 95953560, цахим шуудангийн хаяг: info@khatanbaatar.com,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Тэргүүн чансаа ХХК оноосон нэр, 000171862 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2891298 регистрийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Их тойруу, Премиут палас цогцолбор, 901 тоот, холбоо барих утас: 95000118, 99841211, цахим шуудангийн хаяг: ariunaa@terguunchansaa.com,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✔ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Одод ХХК-ийн захиалгатай, Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 2 давхар зоорьтой 2 давхар 5 блок, 1 давхар зоорьтой 3 давхар 2 блок, нийт 7 блок аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 2 давхар зоорьтой 2 давхар 5 блок, 1 давхар зоорьтой 3 давхар 2 блок, нийт 7 блок аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Одод ХХК-ийн захиалгатай,
Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан
Аялал жуулчлалын зориулалттай нийт 7 блок барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Одод ХХК-ийн Ерөнхий захирал (Д.Оюунсүрэн)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын
үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Огноо 2026 01 10/12/21
Бүртгэсэн: О. Мишэ
УЛААНБААТАР ХОТ

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 22 ДУГААР ХОРООНД БАРИГДСАН ОДОД ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, 7 БЛОК АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

2025 оны 10 дугаар сарын 01 Улаанбаатар хот

Одод ХХК-ийн захиалгатай, Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 2 давхар зоорьтой 2 давхар 5 блок, 1 давхар зоорьтой 3 давхар 2 блок, нийт 7 блок аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр 10:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:00 цагт дуусав.

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1. | Комиссын дарга:<br>Хяналт шалгалтын газрын<br>Барилга байгууламжийн ашиглалт,<br>бүртгэлийн хэлтсийн даргын албан<br>үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. | Комиссын нарийн бичгийн дарга:<br>Одод ХХК-ийн Төслийн зохицуулагч | Б.Оюунбилэгт |
| 3. | Хяналт шалгалтын газрын<br>Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн<br>Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Б.Өнөртэгш |
| 4. | Хяналт шалгалтын газрын<br>Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн<br>Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5. | Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн<br>Техник хяналтын инженер | Н.Наранцацрал |
| 6. | Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн<br>Зүүн түгээх төвийн ахлах инженер | Б.Оргил |
| 7. | Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын<br>Хэрэглэгчдэд үйлчлэх албаны<br>Борлуулалт, мэдээлэл лавлагааны инженер | Г.Өлзийхишиг |
| 8. | Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн<br>Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын<br>Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Н.Даваадэмид |
| 9. | Нийслэлийн Онцгой байдлын газрын<br>Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг<br>төслийн хяналтын ахлах байцаагч /Хошууч/ | Б.Даваасүрэн |
| 10. | Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын<br>Барилга, барилгын материал үйлдвэрлэл,<br>баталгаажуулалтын хэлтсийн мэргэжилтэн | Б.Жаргал |
| 11. | Архивын ерөнхий газрын Үндэсний Төв архивын<br>Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 12. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах<br>Байгууллага: ХУДХБИХолбооны тэргүүн | Ч.Уранчимэг |

13. Ашиглалт хариуцагч байгууллага:
    Тэргүүн чансаа ХХК-ийн Ерөнхий инженер — С.Галбадрах
14. Зураг төсөл зохиогч
    Хатанбаатар ХХК-ийн архитектор — Б.Чулуунцэцэг
15. Барилгын ажил гүйцэтгэгч,
    Эл Жи Жи И ХХК-ийн Гүйцэтгэх захирал — Э.Бат-Амгалан

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хүрэлцэн ирсэн – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Одод ХХК-ийн захиалгатай, Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 2 давхар зоорьтой 2 давхар 5 блок, 1 давхар зоорьтой 3 давхар 2 блок, нийт 7 блок аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн ажлын зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Захиалагч байгууллага:
Одод ХХК-ийн Төслийн зохицуулагч **Б.Оюунбилэгт**

- Улсын комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтэнд хяналт тавьж ажиллана
- Үүрэг даалгаврын биелэлтээр барилгуудыг хүлээн авч ашиглалтанд оруулах саналтай байна

Гүйцэтгэгч байгууллага:
Эл Жи Жи И ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Э.Бат-Амгалан**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна

Зураг төсөл зохиогч байгууллага:
Хатанбаатар ХХК-ийн архитектор **Б.Чулуунцэцэг**

- Худалдаж авах захиалагчийн хүсэлтийн дагуу шаардлагатай гэж үзвэл ХБИ-д зориулсан тоноглолыг угсрах хэрэгтэй
- 11, 22, 14, 23-р байрууд захиалагчийн хүсэлтээр дотор засал болон дотор шугам сүлжээг интерьерийн зургийн дагуу дараа нь хийгдэхээр болсон
- Барилгуудад ашигласан материалуудын сертификатыг бичиг баримтанд хавсаргах
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна

Ашиглалт хариуцагч байгууллага:
Тэргүүн чансаа ХХК-ийн Ерөнхий инженер **С.Галбадрах**

- 24-р байрны узелийн туузыг сольж засварлах
- Үзелиудийн хаягжуулалт гүйцээх
- Хэмжих хэрэгсэл хагарч цуурсаныг солих
- Дулаалга, өнгийн тууз дутуу хэсгүүдийг гүйцээх

ХУДХБНХолбоо (Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага) **Ч.Уранчимэг**

- 7 блок, налуу зам стандартын зориулалтын болгох
- Боржуурыг засах
- Машины "ХБИ" зогсоолд тэмдэглэгээ хийх

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер **Н.Наранцацрал**

- 5 блокын дундах хуваарилах самбар (щит)-ыг дугаарлаж, анхааруулах плакат хадах
- 14-р блок холбогдсон хуваарилах самбарын угсралт, засварын ажлыг гүйцээх
- Айл өрхөд DTSD545 маркийн электрон тоолуур суурилуулсан байна. (Ухаалаг тоолуур, мэдээлэл цуглуулах концентратор) ХҮАТБХ (тоолуурын хэлтэс)-тэй зөвшилцөх. Дэд өртөөний ачааллын тооцоо хийх (айл 1 фаз тоолуур тавих байсан)
- 0.4 кВ кабелиудыг УБЦТС-ний (нийслэл) мэдээллийн санд бүртгүүлж акт авах
- 11-р блокын щитний угсралтын ажлыг хийж гүйцэтгэх
- 10, 14-р блокын 0.4 кВ щит аянгын буултын эсэргүүцлийг хэмжүүлсэн протокол, далд ажлын фото актыг нөхөж үзүүлэх
- ХТП-6964 дэд өртөөг УБЦТС ТӨХК-д хүлээлгэж өгөх баталгаа албан бичиг. Техникийн нөхцлийн 4.3 заалт
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналыг дэвшүүлж байна

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Зүүн түгээх төвийн ахлах инженер **Б.Оргил**

- 22-р байрны холигч узелийн дулаалга хийх
- Холигч насосны узелийн шугам болон тоноглолд чиглэл заасан тэмдэглэгээ, хаягжуулалт бүрэн хийх, аюулгүй ажиллагааны плакат тавьж өгөх
- Гадна худагт шат тавцан гүйцээж хийх
- Зөвлөмж: Тэргүүн чансаа ХХК 3-р хэлхээний буюу хотхоны гидравлик тооцоог хийж хянуулан, халаалтын дотор системийн тохируулгыг иж бүрэн хийх, Цаашид хэрэгцээний халуун усны нэмэлт үүсгүүрийг айл болгонд болон нэгдсэн байдлаар шийдэх. Хүчдэл тасарсан үед ЦТП ба халаалтын эргэлтийн насосыг ажиллуулах нөөц эх үүсвэр шийдэх.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны Борлуулалт, мэдээлэл лавлагааны инженер **Г.Өлзийхишиг**

- Бохир усны худгуудад угсарсан шатуудыг зэврэлтээс сэргийлэн өнгөлөх
- Блок тус бүрийн гадна болон дотор цэвэр усны шинжилгээ өгч, дүгнэлт гаргуулах (Нийслэлийн эрүүл мэндийн газарт)

- УСУГ-тай байгуулсан гэрээг шинэчилж байгуулах
- Нөөцийн савны ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийж, техник ашиглалтын паспорт хөтөлж хэвших
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын Чанар, хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид**

- Давхарын самбар хаягжуулах
- Самбар доторх кабель шугам цэгцлэн хаяглах
- Гадна хотхоны камержуулалт хангалтгүй байгаа тул нэмэгдүүлэх
- Гадна холбооны зураг үзүүлэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай байна

Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материал үйлдвэрлэл, баталгаажуулалтын хэлтсийн Норм, нормативын сан бүрдүүлэлтийн мэргэжилтэн **Б.Жаргал**

- Барилгын төмөр бетон хийцлэлүүдийг эвдэж хаалганы проём гаргаж, хүчитгэлийг буулгасан зөрчил илэрсэн, анхны байдалд оруулах
- Төмөр бетон хийцийн цутгалт стандарт шаардлага хангаагүй байгаад биет байдлын судалгаа хийлгэж, хүчитгэх арга хэмжээ авах
- Газар хөдлөлтийн балл өөрчлөгдсөнтэй холбогдуулан зураг төслийг магадлалд дахин хянуулах
- Барилгын ажлыг бүрэн хийж дуусгах
- Гадна фасадуудыг дахин шинээр сэргээж засварлах, шинэчлэх
- Барилгын бүх зураг төслийн нэршлийг нэг болгох
- Цэцэрлэгийн зориулалтаар ашиглахгүй талаар тайлбар баталгаа ирүүлнэ

Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, хошууч **Б.Даваасүрэн**

- Гадна дулаалгын дүгнэлт, барилга тус бүр фото акт
- Авто зогсоол тус бүрд бие даасан гал унтраах автомат модулийн систем тоноглох
- Галын дохиоллын систем батлагдсан зураг төслийн дагуу хийх, шалгасан акт фото, удирдлагын самбар хийж 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах
- Өөрчлөлтийн зураг хянуулах
- Хараар байгаа 4 барилга гэрээ, хугацаа тусгах
- Захиалагч албан бичиг өгөх
- Зургийн автор дүгнэлт дэлгэрэнгүй өгөх

Үндэсний Төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа**

- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, хуудас дугаарлах, дотоод товьёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**

- Блок тус бүрийн холигч узелийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг ТАД-ын дагуу хаягжуулах
- 11, 22, 14-р блокуудын АС, халаалтын шугам угсралтыг дуусгах, баталгаа ирүүлэх
- Блок тус бүрийн дотор халаалт, АС угсарсан актыг баталгаажуулж шалгуулах
- Блок тус бүрийн гадна дулааны худгийн фото зургийг шалгуулах
- БТХ-ийн дагуу зүгшрүүлэх, тохируулах чанарын баталгаа ирүүлэх
- 1, 10, 11, 14, 22, 23, 24-р байруудын зоорийн давхрын халаах хэрэгсэлд термостат винтель суурилуулах

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Б.Өнөртэгш**

- БТХ-ийн дагуу баталгаа гаргаж ирүүлэх
- Хувийн хэргийг нөхөж шалгуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл нөхөж шалгуулах
- Бетоны бат бэхийн шинжилгээг шалгуулах
- БАЗГ-т тайлбар ирүүлэх
- Ажлын зургуудыг дахин шалгуулах
- Дотор засал хийгдээгүй барилгуудын гэрээг тайлбарын хамт ирүүлэх

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БНбД-11-04-16-ын дагуу зохиогч дүгнэлт бичих
- БТХ-ийн 14.3, 14.6-ын дагуу барилгад чанарын баталгаа гаргаж ирүүлэх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгавар бүрэн хангуулах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Одод ХХК-ийн захиалгатай, Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 2 давхар зоорьтой 2 давхар 5 блок, 1 давхар зоорьтой 3 давхар 2 блок, нийт 7 блок аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Одод ХХК-ийн Ерөнхий захирал (Д.Оюунсүрэн)